

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол шалтгаан)	Хувь
					Эхний хагас жил	Жилийн эцэст		
<b>Стратегийн төлөвлөгөө зорилго 1. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө</b>								
<b>Зорилт 1.1 Хүний хөгжлийн зорилтот түвшинг бүрэн хангана. (НСТ-2)</b>								
1.1.1	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй сургуулийн 24 барилга, өргөтгөлийн төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (МУХЖТ-1.1.5, НХТЖҮЧ-2.3.1, НЗДҮАХ- 2.3.2, НСТ-2.4, НХТ-1.3.9)	УТХО 29,500.0 сая төгрөг, НТХО 8,600.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	33%	36%	60%	Сургуулийн барилга, өргөтгөлийн 24 төсөл, арга хэмжээ 55 хувьтай хэрэгжиж байна. 2 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 55 хувь	92%
1.1.2	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Цэцэрлэгийн барилга, өргөтгөлийн 62 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НХТЖҮЧ-2.2.1, НЗДҮАХ- 2.3.2, НСТ-2.4,НХТ-1.3.8)	УТХО 33,400.0 сая төгрөг, НТХО 22,979.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	33%	45%	60%	Цэцэрлэгийн барилга, өргөтгөлийн 61 төсөл, арга хэмжээ 67 хувьтай хэрэгжиж байна. 1 төсөл, арга хэмжээний гэрээг цуцалсан. 17 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 67 хувь	100%
1.1.3	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын 17 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НЗДҮАХ- 2.3.2, НСТ-2.4, НХТ-1.3.8, 1.3.9)	УТХО 21,160.0 сая төгрөг НТ-3,712.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	22%	30%	60%	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын 17 төсөл, арга хэмжээ 37 хувьтай хэрэгжиж байна. 1 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 37 хувь	62%
1.1.4	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Спорт заал, цогцолборын 4 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-2.3, НХТ-1.2)	УТХО 2,000.0 сая төгрөг НТ-166.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	63%	70%	75%	Спорт заал, цогцолборын 4 төсөл, арга хэмжээ 75 хувьтай хэрэгжиж байна.	100%
<b>Зорилт 1.2. Засаглалын зорилтот түвшинг бүрэн хангана. (НСТ-4)</b>								
1.2.1	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Хорооны цогцолбор, өргөтгөлийн 11 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НХТЖҮЧ-5 3.1, НЗДҮАХ-4.1.1)	УТХО 3,400.0 сая төгрөг, НТХО 1,450.6 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	44%	50%	55%	Хорооны цогцолбор, өргөтгөлийн 11 төсөл, арга хэмжээ 64 хувьтай хэрэгжиж байна. 1 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 64 хувь	100%
<b>Зорилт 1.3. Хотжилтын зорилтот түвшинг бүрэн хангана. (НСТ-6)</b>								

1.3.1	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй бусад барилга байгууламжийн 51 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-6.1)	УТХО 25,700.0 сая төгрөг, НТХО 7,086.9 сая төгрөг НОНХС 364.3 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	47%	53%	60%	Барилга байгууламжийн 50 төсөл, арга хэмжээ 61 хувьтай хэрэгжиж байна. 14 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/829 дугаар Захирамжаар 1 төсөл, арга хэмжээний зөвлөмж шинэчлэн ирсэн. Ажлын явц: 61 хувь	100%
1.3.2	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Инженерийн шугам сүлжээний 80 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-6.5, НХТ-5.3.2, 5.3.13, 5.3.14, 5.)	УТХО 10,800.0 сая төгрөг НТХО 13,400.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	49%	55%	60%	Инженерийн шугам сүлжээний 75 төсөл, арга хэмжээ 67 хувьтай хэрэгжиж байна. 17 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж, хүлээлгэж өгсөн. 5 төсөл, арга хэмжээний гэрээг цуцалсан. Ажлын явц: 67 хувь	100%
1.3.3	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй их засварын хүрээнд хийгдэж буй 76 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-6.1)	УТХО 6,300.0 сая төгрөг 1,500.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	46%	60%	80%	Их засварын хүрээнд хийгдэж буй 76 төсөл, арга хэмжээ 94 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. 54 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 94 хувь	100%
1.3.4	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй тохижилтын 113 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-6.1)	УТХО 8,522.0 сая төгрөг НТХО 1,215.5 сая төгрөг НОНХС 1,116.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	58%	65%	75%	Тохижилтын 112 төсөл, арга хэмжээ 85 хувьтай хэрэгжиж байна. 49 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. 1 төсөл, арга хэмжээний гэрээг цуцалсан. Ажлын явц: 85 хувь	100%
1.3.5	2022-2023 онд дамжин хэрэгжиж буй гэрэлтүүлэг, камержуулалтын 16 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах (НСТ-6.1)	УТХО 1,386.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	55%	65%	80%	Гэрэлтүүлэг, камержуулалтын 16 төсөл, арга хэмжээ 92 хувьтай хэрэгжиж байна. 10 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 92 хувь	100%
<b>Стратегийн төлөвлөгөө зорилгын хэрэгжилт, хувь</b>								<b>95%</b>
<b>Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө</b>								
<b>Зорилт 2.1. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих</b>								
2.1.1	Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) төсөл, арга хэмжээнд Барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах, барилга ашиглалтад оруулах комиссыг ажиллуулж, дүгнэлтийг баталгаажуулах, гэрээг дүгнэж эцсийн санхүүжилтийг олгох	УТХО 22,000.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	80%	90%	100%	Төсөл, арга хэмжээ 90 хувьтай хэрэгжиж байна. Гадна цахилгаан хангамжийн комисс ажиллаж, акт баталгаажиж байна.	90%

2.1.2	Нийтийн тээврийн автопарк (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах, барилга ашиглалтад оруулах комиссыг ажиллуулж, дүгнэлтийг баталгаажуулах, гэрээг дүгнэж эцсийн санхүүжилтийг олгох	УТХО 45,523.1 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	5%	80%	Ерөнхий төлөвлөгөө, техникийн нөхцөл, газар тодорхойгүй, ажил эхлүүлэх зөвшөөрөл олгоогүй зэргээс шалтгаалж, ажил эхлэх хугацаа оройтсон. Одоогоор Гарааш 1, 2 төмөр каркас, Агуулах 1, 2 дотор хар шавар, Үйлчилгээний барилгын дүүргэлт, ШТС-ын ажил дуусаж, уурын зуухны барилгын суурийн ажлууд тус тус хийгдэж байна. Гадна дулааны ажил уурын зуухны барилга хүртэл таталт хийсэн. Гарааш 1, 2 дугаар барилгын сэндвичэн хавтан хийгдэж байна. Ажлын явц: 65 хувь	81%
<b>Зорилт 2.2. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих</b>								
2.2.1	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих камер, гэрэлтүүлгийн 10 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах	НОНХС 539.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	10%	80%	595 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаж, 2 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан, акт баталгаажсан. Ажлын явц: 91 хувь	100%
2.2.2	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих дээвэр, фасад, их засварын 7 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах	НОНХС 1,650.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	10%	80%	974,1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаж, 4 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан, акт баталгаажсан. Ажлын явц: 96 хувь	100%
2.2.3	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих тохижилтын 35 төсөл, арга хэмжээнд барилга угсралтын ажлын явцын хяналт тавих, явцын гүйцэтгэл хянаж баталгаажуулах	НОНХС 7,465.00 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	10%	80%	8,9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 51 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдаж, 19 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын явц: 65 хувь	81%
2.2.4	Гэрээний үүргийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавихдаа батлагдсан ажлын зураг төслөөр барилгын норм, дүрмийн шаардлага болон, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 18-26 дугаар тогтоолоор батлагдсан хотын стандартын хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт арилгуулах арга хэмжээг авч гүйцэтгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	100%	Захиалагчийн хяналтыг тавихдаа батлагдсан ажлын зураг төслөөр барилгын норм, дүрмийн шаардлага болон, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 18-26 дугаар тогтоолоор батлагдсан хотын стандартын хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт арилгуулан ажиллаж байна.	100%
<b>Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилгын хэрэгжилт, хувь</b>								<b>92%</b>
<b>Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 3.</b>								
3.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	100%	Эзийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аливаа өр, авлага үүсгэлгүй ажилласан.	100%

3.2	2023 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх (Конракт гэрээгээр батлагдсан эдийн засгийн зорилтот түвшний хүрээнд)	Орлого 5,828 сая төгрөг Зардал 5,269 сая төгрөг Ашиг 503 сая төгрөг	Эдийн засгийн зорилтот түвшний биелэлт, хувь	-	100%	Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана	2023 оны эдийн засгийн зорилтот түвшний хүрээнд 5,8 тэрбум төгрөгийн орлоготой 4,8 тэрбум төгрөгийн зардалтай, 1,02 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2/725 дугаар албан бичгээр Нийслэлийн Өмчийн харилцааны газраас батлагдаж ирүүлснийг мөрдлөг болгон ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар 5,8 тэрбум төгрөгийн орлоготой 4,6 тэрбум төгрөгийн зардалтай 973 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж байна.	100%
3.3	Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	I-IV улирал	2023 оны жилийн эцсийн байдлаар (өссөн дүнгээр) Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14.4 тэрбум, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9,3 тэрбум, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 61,5 тэрбум төгрөг, нийт 85,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	100%
3.4	Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн нийслэлд холбогдолтой заалтуудын хэрэгжилтийг тайлагнах	-	Дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр "2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" тогтоолыг хяналтад авсан. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу "Шүүр" ажиллагааг хэрэгжүүлэн Төрийн албаны хууль, тогтоомж, холбогдох, шаардлагыг зөрчин томилогдсон албан хаагчдыг шалгах ажлыг Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулж холбогдох тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр (2023.04.05 №2/1151) хүргүүлэв. Стандарт, хэмжил зүйн газрын даргын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн с/49 дүгээр "Үндэсний стандарт шинээр батлах тухай" тушаалыг хяналтад авсан. Тус ажлын хүрээнд Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага батлагдсаныг Барилга захиалагчийн хэлтсийн дарга Б.Ганзоригт хүргүүлэв. 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахаар бэлтгэж байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Мишигдоржоос ирүүлсэн заалтын дагуу ERP цахим системээр 2 удаа хүргүүлэв.	100%

3.5	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	-	НЗД Зөвлөлийн хурлын хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлд хотын стандартыг мөрдүүлэх тухай үүрэг даалгаврын хүрээнд Барилга захиалагчийн хэлтсийн дарга Б.Ганзоригт танилцуулж Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2.4 холбогдох заалтад тусган батлуулав.</p> <p>Мөн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлд "Нийслэлийн нутгийн захиргааны төв" цогцолбор барилгын Б блок барилгын ажлыг хийж дуусгах үүрэг даалгаврын хүрээнд хийсэн ажлын явцын мэдээг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулсан.</p>	100%
3.6	Газрын үйл ажиллагааны тайлан (14 хоног, улирал, жилийн эцэс) гарган холбогдох дээд байгууллагад хугацаанд нь хүргүүлэх	-	Хүргүүлсэн тайлан, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Газрын үйл ажиллагааны тайланг хагас жилийн байдлаар нэгтгэн боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр (2023.07.07 №2522) хүргүүлсэн. Мөн нэгдүгээр болон гуравдугаар улирлын тайланг нэгтгэн боловсруулж Газрын даргад танилцуулсан.</p> <p>Газрын үйл ажиллагааны 14 хоногийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу нэгтгэн боловсруулж 18 удаа сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн пүрэв гаригт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Захиргааны хэлтсийн үйл ажиллагааны тайланг 14 хоног, улирал, хагас жилийн байдлаар нэгтгэн, боловсруулж хэлтсийн даргаар батлуулан Газрын үйл ажиллагааны тайланд тухай бүр тусгасан.</p> <p>Газрын бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэхээр нэгтгэж байна.</p>	100%

3.7	egr.ulaanbaatar.mn Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг иж бүрэн ашиглах, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хэрэгжүүлсэн	99,5%	100%	I-IV улирал	<p>2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар манай газарт 3337 албан бичиг ирсэн бөгөөд хариутай 1171, хариугүй 2166 байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан бичиг 3, хугацаа хэтрүүлэн шийдвэрлээгүй албан бичиг байхгүй, албан бичгийн шийдвэрлэлт 99,8 хувьтай байна. Хугацаа хэтрэлт өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 62,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 99,8, хариугүй бичгийн шийдвэрлэлт 99,9 хувь, шийдвэрлэлтийн дундаж хоног 9,3 байна. Энэ нь өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулбал: Хариутай бичгийн шийдвэрлэлт 0,3 хувиар, хариугүй бичгийн шийдвэрлэлт 0,1 хувиар өссөн сайн талтай байна.</p> <p>Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын А/48 дугаар тушаалаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын дагуу албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	99%
3.8	"Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт" боловсруулан батлуулж Баримт бичиг, материалуудыг ХХНЖ-ын жагсаалтын дагуу жил бүрийн 1 улиралд багтаан хэлтсүүдээс хүлээн авах, архивт нөхөн бүрдүүлэлт хийх	-	ХХНЖ-ын дагуу баримтыг нөхөн бүрдүүлсэн	2022 оны батлагдсан бүртгэл	Нөхөн бүрдүүлсэн баримтын тоо	I улирал	<p>2023 онд хөтлөгдөх байгууллагын "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг боловсруулахад ажилтнуудаас санал авч, нэгтгэн боловсруулан Газрын даргаар 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлуулав.</p> <p>2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн батлагдсан хуваарийн дагуу газрын архивт 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн батлагдсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу байнга хадгалах 577 ХН, түр хадгалах 684 ХН, 70 жил хадгалах 10 ХН, тусгай төрөл 12 ХН, нийт 1283 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, газрын архивт нөхөн бүрдүүлэлт хийв.</p>	100%

3.9	Газрын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.	-	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	980 албан хаагч сургалтад хамрагдсан. 94.3%	Хөтөлбөрийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлн э. 100%	I-IV улирал	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотойгоос бусад сургалтад төсөв гаргах боломжгүй тул Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдаж байгаа төлөвлөгөөт сургалтад газрын албан хаагчдыг хамруулан ажиллав.</p> <p>2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар хувь хүнийг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 78 сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 799 албан хаагч хамрагдав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Гадаад улсын томилолт, семинар – 6 удаа, 12 ажилтан</li> <li>-Хувь хүний хөгжлийг дэмжих, чадавхжуулах сургалт – 8 удаа, 64 ажилтан</li> <li>-Дотоод сургалт (НХОГ) – 10 удаа, 427 ажилтан</li> <li>-Зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэг–8 удаа, 38 ажилтан</li> <li>-Мэргэшүүлэх сургалт 46 удаа, 258 ажилтан тус тус хамрагдав.</li> </ul> <p>Хөтөлбөрийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Газрын хөдөлмөрийн “дотоод журам”-ын холбогдох заалтын хүрээнд тайлант хугацаанд 35 ажилтан, албан хаагчид:</p> <ul style="list-style-type: none"> <li>-дэмжлэг 88.100.000 төгрөг, тусламж 15.900.000 төгрөг, нийт 104.000.000 төгрөгийг тус тус тушаалаар баталгаажуулав.</li> </ul>	100%
-----	--	---	--	---	---	-------------	---	------

3.10	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар батлагдсан "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд "Охь мандал" ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр мод арчлах, ургуулах хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний хүрээнд заавар, зөвлөгөөний дагуу мод тарьж, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Дээд салхитын аманд 05 дугаар сарын 12-ны өдөр 30 ширхэг Шинэс модыг, 26 албан хаагч тарив. Тайлан мэдээг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 5/1813 дугаар албан бичгээр Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлэв.</p> <p>Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 05/1824 дугаар "Ногоон хот-Иргэний оролцоо" 2023 оны намрын мод тарих, арчлах арга хэмжээ зохион байгуулах тухай албан бичиг ирүүлсэн. Манай газрын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 05/3720 дугаар албан бичгээр хариу хүргүүлэв.</p>	100%
3.11	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.	-	Хуулийн хэрэгжилтийг хангах	100%	100%	I-IV улирал	<p>"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг танилцуулах Цагдаагийн Ерөнхий газраас бэлтгэсэн танилцуулга цахим хичээлийг 2023 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, зурагт хуудсуудыг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Газрын сайт, НХОГ дотоод сүлжээнд тус тус байршуулав.</p> <p>2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" сургалт Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэстэй хамтран зохион байгуулж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллав.</p>	100%



3.12	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Хуулийн хэрэгжилтийг хангах	100%	100%	I-IV улирал	<p>“Нийслэлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг зохион байгуулав. 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 5/4767 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв. (Биелэлт 95 хувь)</p> <p>-Жендэрийн Үндэсний хороотой хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” танхимын сургалт зохион байгуулж, нийт 53 ажилтан хамрагдав.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Газрын даргын 2023 оны А/50 дугаар тушаалаар “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам”, 2023 онд хэрэгжүүлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллав.</p>	95%
3.13	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах” А/64 дүгээр тушаал баталсан. Тус ажлын хэсэг газрын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс QR код бүхий судалгаа, санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Холбогдох хууль, журамд нийцүүлэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллаж байна.</p>	100%
<b>Хуулиар олгосон чиг үүргийн хэрэгжилт, хувь</b>								<b>95%</b>
<b>Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 4. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоол</b>								
4.1	Улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	83%	100%	100%	<p>Улс, Нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр 2023 оны 12 сарын 08-ны байдлаар 1,468.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 715 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Ажлын дундаж гүйцэтгэл 75 хувьтай. Үүнээс:</p> <p>- Он дамжсан 1,267.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 472 төсөл, арга хэмжээ, ажлын дундаж гүйцэтгэл 80 хувьтай.</p> <p>- 2023 оны ажил 201.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 243 төсөл, арга хэмжээ, ажлын дундаж гүйцэтгэл 68 хувьтай.</p>	100%

4.2	Хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газар хүргүүлэх, хамтран ажиллах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	<p>Нийслэлийн 9 дүүрэгт 2024 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой зураг төсөв нь бэлэн барилга угсралтын 10 төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж <a href="https://pimis.publicinvestment.gov.mn">https://pimis.publicinvestment.gov.mn</a> программд оруулсан бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 4/1273 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд санал бэлтгэх, хүргүүлэх ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлэх боломжтой зураг төсөв бэлэн 265.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/1968 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2022 онд манай газарт бүрэн дууссан 275 ажлын нийгэм эдийн засгийн дүн шинжилгээ хийн танилцуулга бэлтгэсэн.</p> <p>Мөн дүүргүүдийн хэрэгцээ шаардлага болон тулгамдаж буй асуудлын хүрээнд 2022 онд 7 төсөл боловсруулж, төслийн танилцуулга бэлтгэн холбогдох газруудад хүргүүлж ажилласан бөгөөд "Сургууль цэцэрлэгийн бүсэд тэмдэг тэмдэглэгээ хийх төсөл" нь Баянзүрх дүүргийн Орон Нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байна. 2023 онд "Тархины цус харвалтын дараах нөхөн сэргээх сувилал байгуулах" төслийг шинээр санаачлан боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын эмэгтэй төлөөлөгчдөд болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд танилцуулав.</p>	100%
4.3	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нийслэлд татах ажлыг зохион байгуулах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	<p>2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Олон Улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум"-д хэлтсийн 4 мэргэжилтэн оролцов. 2022 онд боловсруулсан төслүүдийн танилцуулга бэлтгэн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар Хөгжлийн корпорацид цаасан суурьтайгаар хүргүүлэв.</p>	100%

4.4	Зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу худалдан авах ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд 200 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс 191 төсөл арга хэмжээний бэлтгэл бүрэн хангагдсан. 14 төсөл арга хэмжээ хүчингүй болсон байна. Захирамжаар хэрэгжиж буй ажлын явц 95.9 хувьтай байна. Гэрээ байгуулан хэрэгжүүлж буй 42 ажил байгаа бөгөөд биелэлт 56 хувьтай хэрэгжиж байна. Түлхүүр гардуулах нөхцөлтэй барилга, инженерийн шугам сүлжээний шинээр ирсэн 283 төсөл арга хэмжээний зураг төсвийн ажлын явцад хяналт хийж, 192 төсөл арга хэмжээний зураг төсөв иж бүрэн боловсруулагдан, магадлалаар баталгаажуулж, хүлээн авч холбогдох хэлтэс, байгууллагад хүргүүлсэн. Ажлын явц 79.5 хувийн биелэлттэй байна.	100%
4.5	Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, шинэ барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг шалган заавар өгч, хянаж баталгаажуулах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	Санхүүжилт хүссэн 853 гүйцэтгэлийн баримт бичгийг хүлээн авч, баримт бүрдлийг шалгах, заавар зөвлөгөө өгөн, хянан баталгаажуулж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14,4 тэрбум, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9,3 тэрбум, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 61,5 тэрбум төгрөг, нийт 85,1 тэрбум төгрөгийн олгон ажиллаж байна.	100%
4.6	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ил, далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, гүйцэтгэлийг хянаж батлах, санхүүжүүлэх, объектыг ашиглалтанд оруулах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	2023 оны жилийн эцсийн байдлаар 1,4 их наяд төгрөгийн гэрээний дүнтэй 715 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Үүнээс нийт 275 төсөл, арга хэмжээний арга хэмжээний ил далд ажлын актыг баталгаажуулж, материалын стандартыг хангуулж, байнгын ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн байна.	100%
4.7	Төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх, тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 160 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлд хяналт, тавьж тайлагнан ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж сангийн яамны <a href="http://www.publicinvestment.gov.mn">www.publicinvestment.gov.mn</a> сайтад байршуулан ажиллаж байна.	100%

4.8	Барилга угсралтын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлэх талаар санаачлагатай ажиллаж хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>1. Сонгинохайрхан дүүргийн хатуу түлшний зуухаар халаадаг 121 дүгээр сургуулийг Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар тоног төхөөрөмжийг нийлүүлж, Монгол улсын талаас газар шороо, цооног, шугамын ажлын зардлыг гарган, газрын гүний дулааныг ашиглан тухайн барилгын халаалтыг шийдвэрлэх төсөл юм. Тус технологи нь газрын гүнээс буюу 120 метрээс +5 градусын дулаантай антифризийг авч, дулааны насосруу даралтаар шахан халааж, конденсаци үүсгэх зарчмаар энерги гарган авч, дулаан гаргадаг. Мөн зуны улиралд тухайн барилгын дээвэр дээр нарны панел суурилуулан түүнээс гарган авсан дулаанаа эргэн газрын хөрсөнд шингээс замаар газрын дулааныг нөхөн сэргээх зарчмаар ажилладаг нь байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал бага, сэргээгдэх эрчим хүч юм.</p> <p>2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүрээ амаржих газрын барилгын их засварын ажлын дотор тоосгон хамар ханыг керамзитэн бетонон дүүргэлттэй гипсэн ханаар хийж гүйцэтгэж байна.</p> <p>Керамзитын гол түүхий эд нь шавар бөгөөд, түүний үрэл нэг бүрийн дотор агаарын бөмбөлөг агуулагдсанаар керамзитыг дулаан тусгаарлах онцгой шинж чанартай болгож, мөн хөнгөхөн байх тусам дулаан хадгалалт сайтай болдог. Иймээс барилгын даацад ирэх нийт ачааллыг багасгаж өгч байгаагаараа давуу талтай, мөн энэхүү материалыг дотооддоо үйлдвэрлэж байгаа учраас улс орны эдийн засгийг дэмжсэн худалдан авалт юм.</p>	100%
<b>Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, хувь</b>								<b>100%</b>
<b>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 5. төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох.</b>								
5.1	Газрын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг нийт 81 гүйцэтгэгч байгууллагаас авсан бөгөөд судалгаанд оролцогчдын 90 хувь нь манай газрын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай гэсэн үнэлэлт өгсөн ба одоогоор арга хэмжээ авах шаардлагатай гомдол саналгүй байна.</p>	100%
5.2	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	<p>Манай газарт хяналт тавин хэрэгжиж буй хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ бүтээн байгуулалтын 2022 оны цахим 1 ном, 2023 оны 75 мэдээ, зургийн хамт газрын албан ёсны цахим хуудас болох <a href="http://invest.ub.gov.mn">invest.ub.gov.mn</a> вэб нээлттэй байршуулав.</p>	100%

5.3	“Цахим улаанбаатар” төсөл, “digital first” аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	100%	Цахим Улаанбаатар, Digital first аяны хүрээнд: -2023 оны 02 сарын 04-ний өдөр Төрийн албан хаагчдын тоон гарын үсгийн ашиглалт, болон тоон гарын үсэг авахад шаардлагатай мэдээллийг албан хаагчдын НХОГ дотоод сүлжээнд байршуулан, нийт албан хаагчдад сурталчлав. -2023 оны 08 сарын 16-ний өдөр Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр хэлэлцсэн “Дижитал сити” төслийн мэдээллийг албан хаагчдын НХОГ дотоод сүлжээнд байршуулан, нийт албан хаагчдад мэдээлэв. -2023 оны 12 сарын 01-ний өдөр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын цахим хуудсанд “Цахим хөгжлийн багц хуулийн тухай” дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан иргэдэд сурталчлав.	100%
5.4	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь багтаан хүлээн авч ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр ирүүлсэн 1 гомдол байна. 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр иргэн Д.Одгэрэл Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, 8 дугаар хэсэгт “Ар дааган” ХХК үерийн усны далан шугамын ажил хийж байсан ба 2018 оноос хойш хийгдээгүй дутуу орхисон талаар гомдол гаргасан. Иргэн Д.Одгэрэлд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 2/1568 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв. Ажлын 5 хоногт багтаан асуудлыг шийдвэрлэв.	100%
5.5	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Дотоод бүртгэл мэдээллийн Investpro.ub.gov.mn цахим системийг шинэчлэн хөгжүүлж, гар утасны аппликэйшн болон шинэ вэб хувилбараар хөгжүүлэв.	100%
5.6	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Erg.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар нийт 156 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. 152 буюу 97.44 хувь өргөдөл, гомдол шийдвэрлэгдэж, 4 буюу 2.56 хувь өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх шатандаа судлагдаж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэх явцад 21 зөрчил илэрсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	97%

5.7	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шатанд нийт 2023-2023 оны хооронд нийт 23 хэрэг маргаан хянагдаж байна. Захиргааны хэргийн шүүхэд нийт 5 хэрэг, үүнээс эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон 3 хэрэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхэд 1, Давж заалдах шатын шүүхэд 1 хэрэг байна. Иргэний хэргийн шүүхэд 18 хэрэг маргаанаас эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон 3 хэрэг, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 7 хэрэг, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажиллагаа хийгдэж байгаа 8 хэрэг байна. Шүүхийн шатанд байгаа хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан нийт 55 удаа шүүх хуралд оролцсон байна.	100%
5.8	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	I-IV улирал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/429 дугаар албан бичиг (санал ирүүлэх тухай)-ийн дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар өөрчлөлт оруулах шаардлагатай захиргааны болон хэм хэмжээний актад санал өгч 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/285 дугаар албан бичгээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 03/5849 дугаар албан бичгийн дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн барих Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал өгч 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 5/3476 дугаар албан бичгээр хариуг тус тус хүргүүлэн ажиллав.	100%
<b>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хэрэгжилт, хувь</b>								<b>100%</b>
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>								<b>96%</b>

Төлөвлөгөөг хянасан:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Төлөвлөгөө тайлагнасан:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Төсвийн Шууд захирагч

(Б.МӨНХБАТ)

(огноо)

2023.12.11

Нэгжийн дарга

(С.ЦЭДЭНСОДНОМ)

(огноо)

2023.12.11